



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 1/63

Хархорин сум

**Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь заалт, Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтныг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээг зохион байгуулах, хийж гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Засаг даргын орлогч)
Гишүүд: Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
Б.Нямсүрэн ("Өвдөлгөөн ундарга" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Гантөмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Ө.Энхжаргал (4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)
Ц.Гомбосүрэн (8 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Тархвар зүйч)

2. Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэн, дүн мэдээг тухай бүр танилцуулахыг мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн эмч (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг), (Б.Нямсүрэн) нарт тус тус даалгасугай.

3. Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээний зар, мэдээг малчдад хүргэж, товлосон газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон газар тогтоосон хугацаанд арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад тус тус үүрэг болгосугай.

401100125

4.Ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтанд байнгын хяналт тавин ажиллаж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүрт нь мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид мэдээлэн ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Э.Нарангарав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ